



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 22 өдөр

Дугаар А/174

Хэрлэн сум

Тоног төхөөрөмж авах ажлын
гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах
ажлын хэсэг байгуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1, 45 дугаар зүйлийн 45.2.2, 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх хэсэг, 47 дугаар зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 онд хэрэгжих аймгийн Засаг даргын Тамгын газарт санал хураах тоног төхөөрөмж авах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга:	Ж.Гантулга	Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга
Нарийн бичгийн дарга:	Н.Үнэнбат	Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн
Гишүүд:	Ж.Энхбат	Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн мэргэжилтэн

2.Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулахыг Ажлын хэсгийн дарга (Ж.Гантулга)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ